

**“ТӨСВИЙН ХЭМНЭЛТИЙН ГОРИМД ШИЛЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” ЗАСГИЙН ГАЗРЫН 147 ДУГААР  
ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН 2015 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН**

Статистикийн хэлтэс

2015.03.25

дд	Тогтоолын заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт
1	Бүх шатны Засаг даргын орлогч, төсөвт байгууллагын дэд дарга, яам, агентлагийн газрын орлогч дарга, даргын туслах, төсвөөс цалинждаг зөвлөх зэрэг орон тоог цөөлөх, цомхтгох	Хэлтсийн үйл ажиллагаанд хамаарахгүй заалт	
2	Төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүрэгтэй харуул хамгаалалт, халаалт дулаан, цэвэрлэгээ зэрэг үйлчилгээг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх, төрийн албаны гэрээт ажилтны орон тоог 50 хувиар бууруулах санал боловсруулж, шийдвэрлүүлэх	Гэрээт ажилтны сарын хөдөлмөрийн хөлсөнд сард дунджаар ажиллах цагийг тооцож тохирсон цалин хөлсийг олгоно.	Нягтлан бодогчийг сард 87 цаг ажиллахаар тооцож 10000 төгрөг, нярвыг сард 43 цаг ажиллахаар тооцож 50000 төгрөг олгохоор харилцан тохиролцож гэрээ байгуулсан.
3	Төсвийн санхүүжилтийг бууруулсанаар өр, авлага үүсгэхгүйгээр зардал хэмнэх боломжийг дайчлах	Сар бүр өр авлагын мэдээг нарийн гаргаж сар дамнуулан өр, авлага үүсгэхгүй байх зорилт тавин ажиллаж байна. Төсөв хүрэлцээгүй өр үүссэн тохиолдолд тайланд өр үүсэхгүй байхаар яаралтай арга хэмжээ авна.	2015 оны 1-р улиралд өр, авлага үүсгээгүй ажилласан.
4	Улсын төсвийн татаас, орон нутгийн төсвийн урсгал зардлыг 20-иос доошгүй хувиар бууруулах	Хэлтсийн үйл ажиллагаанд хамаарахгүй заалт	
5	Шинээр орон тоо нэмэгдүүлэхгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулж орон тоог бууруулах, сул чөлөөтэй орон тоонд томилгоо хийхгүй байх	Батлагдсан болон зөвшөөрөгдсөн орон тоогоор үйл ажиллагаагаа явуулна.	Батлагдсан орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж байна.
6	Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай “Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолоор тогтоосон албан тушаалын болон албан ажлын автомашины хэрэглээний зардлыг 20 хүртэл хувиар хэмнэх	Шатахууны зарцуулалтыг төсвөөс баталсан санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлж ажиллана.	Шатахууныг зардлыг төсвийн хүрээнд зарцуулж байна.

7	Гадаад албан томилолтын зардлыг бууруулах, зайлгүй тохиолдолд зорчих төлөөлөгчийн тоог цөөлөх, төсвийн хөрөнгөөр бизнес ангиллын нислэгээр зорчихгүй байх	Хэлтсийн үйл ажиллагаанд хамаарахгүй заалт
8	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх	Хэлтсийн үйл ажиллагаанд хамаарахгүй заалт
9	Хурал, сургалт, зөвөлгөөний давтамжийг багасгах, зайлшгүй хийх тохиолдолд төлөөлөгчдийн тоог цөөн, оновчтой, богино хугацаанд хийхээр эсхүл цахим хэлбэрээр зохион байгуулах	Хэлтсийн үйл ажиллагаанд хамаарахгүй заалт

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН : МЭРГЭЖИЛТЭН

С.ЭРДЭНЭЗАЯА

ХЯНАСАН: СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Я.ОТГОНБАЯР